



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/007/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот

2025 он

Санхүү, нийцлийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг  
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn  
Аудитын менежер: П.Чанцалдулам  
Утас:260949 Цахим хаяг:chantsaldulamp@audit.gov.mn  
Аудитор: О.Наранбат  
Утас: 261628 Цахим хаяг: naranbato@audit.gov.mn  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ниямазон аудит ХХК-ийн захирал  
З.Цээнээ  
Утас: 70145906 Цахим хаяг: audit@nmz.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30.  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ  
КЛИРИНГИЙН ТӨВ ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
О.ЭРДЭНЭГЭРЭЛ ТАНАА

2025.03.17 № 07/1065  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Төлөөлөн удирдах зөвлөлийн 2, 7, 19, 23 дугаар тогтоолоор Монгол банкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж, хамгийн өндөр хадгаламжийн хүүний санал ирүүлсэн 2 банканд нийт 2,990.0 сая төгрөгийг 180 хоногийн хугацаагаар хадгалуулсан байна.

### Аудитын гол асуудал

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 01 дүгээр тогтоолоор 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд нийт орлогыг 976.3 сая төгрөг, нийт зардлыг 938.7 сая төгрөг, татварын өмнөх ашгийг 37.6 сая төгрөг, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 1,852.2 сая төгрөгөөр тус тус баталжээ.

Гүйцэтгэлээр нийт 1,135.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 947.8 сая төгрөгийн зардал гарган, 187.7 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

## Бусад асуудлын хэсэг

Компани нь Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	5,538,695,029.20	5,814,390,620.68
1.1.2	Дансны авлага	75,041,780.81	31,986,575.38
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	7,073,039.74	20,000,000.00
1.1.4	Бусад авлага	9,172,473.08	8,664,203.40
1.1.6	Бараа материал	5,141,821.00	5,142,061.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	14,925,433.63	17,632,116.00
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>5,650,049,577.46</b>	<b>5,897,815,576.46</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	176,671,678.09	155,106,702.17
1.2.2	Биет бус хөрөнгө	84,584,855.13	69,459,714.68
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	9,026,335.73	4,315,333.14
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>270,282,868.95</b>	<b>228,881,749.99</b>
	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,920,332,446.41</b>	<b>6,126,697,326.45</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	-	2,448,657.53
2.1.1.3	Татварын өр	9,917,038.76	-
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	2,733,010,265.89	2,798,332,412.67
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>2,742,927,304.65</b>	<b>2,800,781,070.20</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	10,252,858.90	5,541,856.31
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>10,252,858.90</b>	<b>5,541,856.31</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>2,753,180,163.55</b>	<b>2,806,322,926.51</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч: төрийн	2,000,000,020.75	2,000,000,020.75
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	23,781,409.08	23,781,409.08
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	470,797,343.22	470,797,343.22
2.3.9	Хуримтлагдсан ашиг	672,573,509.81	825,795,626.89
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>3,167,152,282.86</b>	<b>3,320,374,399.04</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>5,920,332,446.41</b>	<b>6,126,697,326.45</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>513,451,526.18</b>	<b>926,402,179.76</b>
2	Борлуулалтын өртөг	-	-
3	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>513,451,526.18</b>	<b>926,402,179.76</b>
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүгийн орлого	175,001,937.59	209,076,100.99
6	Бусад орлого	2,620,007.04	14,807.87
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	687,724,079.55	947,757,653.45
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	-	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(155,461.49)	1,525.83
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал )</b>	<b>3,193,929.77</b>	<b>187,736,961.00</b>
19	Орлогын татварын зардал	17,500,193.76	20,907,610.11
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>(14,306,263.99)</b>	<b>166,829,350.89</b>

Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн  
аудитын хураангуй тайлан

**2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	<b>2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>2,000,000,020.75</b>	<b>23,781,409.08</b>	<b>470,797,343.22</b>	<b>683,114,407.44</b>	<b>3,177,693,180.49</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	3,765,366.36	3,765,366.36
3	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>2,000,000,020.75</b>	<b>23,781,409.08</b>	<b>470,797,343.22</b>	<b>686,879,773.80</b>	<b>3,181,458,546.85</b>
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(14,306,263.99)	(14,306,263.99)
9	<b>2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>2,000,000,020.75</b>	<b>23,781,409.08</b>	<b>470,797,343.22</b>	<b>672,573,509.81</b>	<b>3,167,152,282.86</b>
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(13,607,233.81)	(13,607,233.81)
11	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>2,000,000,020.75</b>	<b>23,781,409.08</b>	<b>470,797,343.22</b>	<b>658,966,276.00</b>	<b>3,153,545,049.05</b>
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	166,829,350.89	166,829,350.89
17	<b>2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>2,000,000,020.75</b>	<b>23,781,409.08</b>	<b>470,797,343.22</b>	<b>825,795,626.89</b>	<b>3,320,374,399.94</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	82,135,001,197.64	251,725,050,576.99
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	494,599,409.49	916,932,253.02
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	696,244.00
	Бусад мөнгөн орлого	81,640,401,788.15	250,807,422,079.97
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	80,912,034,663.67	251,694,760,838.93
	Ажиллагчдад төлсөн	325,758,769.37	445,876,135.95
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	100,132,637.52	130,103,029.15
	Бараа материал худалдан авахад төлсөн	5,574,176.00	3,314,196.00
	Ашиглалтын зардалд төлсөн	60,719,116.03	61,610,000.00
	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	-
	Татварын байгууллагад төлсөн	38,923,205.06	101,721,841.30
	Даатгалын төлбөрт төлсөн	-	500,000.00
	Бусад мөнгөн зарлага	80,380,926,759.69	250,951,635,636.53
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>1,222,966,533.97</b>	<b>30,289,738.06</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	132,367,524.96	256,696,017.00
	Хүлээн авсан хүүний орлого	132,367,524.96	256,696,017.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	117,195,748.00	11,247,455.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	111,035,748.00	11,247,455.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	6,160,000.00	-
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>15,171,776.96</b>	<b>245,448,562.00</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
	Төлсөн ногдол ашиг	-	-
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>4</b>	<b>Валютын ханшийн зөрүү</b>	<b>(7,449.33)</b>	<b>(42,708.58)</b>
<b>5</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>1,238,130,861.60</b>	<b>275,695,591.48</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>4,300,564,167.60</b>	<b>5,538,695,029.20</b>
<b>7</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>5,538,695,029.20</b>	<b>5,814,390,620.68</b>

**2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2023 оны гүйцэтгэл	2024 он		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
			1	2	3=1-2	
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</b>	<b>691,073.5</b>	<b>976,300.0</b>	<b>1,135,494.6</b>	<b>(159,194.6)</b>	<b>116.3</b>
1.1	Клирингийн шимтгэлийн орлого	469,451.5	754,300.0	890,402.2	(136,102.2)	118.0
1.2	Гишүүний хураамж	44,000.0	35,000.0	36,000.0	(1,000.0)	102.9
1.3	Хүүний орлого	175,001.9	187,000.0	209,076.1	(22,076.1)	111.8
1.4	Бусад орлого	2,620.0	-	16.3	(16.3)	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	<b>687,879.5</b>	<b>938,710.3</b>	<b>947,757.7</b>	<b>(9,047.4)</b>	<b>101.0</b>
2.1	Үйл ажиллагааны зардал	633,190.9	890,710.3	899,820.1	(9,109.8)	101.0
2.2	Элэгдлийн зардал	54,688.7	48,000.0	47,937.6	62.4	99.9
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ</b>	<b>3,193.9</b>	<b>37,589.7</b>	<b>187,736.9</b>	<b>(150,147.2)</b>	<b>499.4</b>
4	Орлогын албан татвар	17,500.2	18,700.0	20,907.6	(2,207.6)	111.8
5	Татвар төлсний дараах ашиг	(14,306.3)	18,889.7	166,829.3	(147,939.6)	883.2
6	Төрийн өмчийн ногдол ашиг	-	9,444.8	-	9,444.8	0.0
7	Ажиллагсдын тоо	15	17	17	-	100.0
8	Цалингийн сан	382,693.2	530,854.9	524,421.9	6,433.0	98.8
9	Орлогын 1 төгрөгт ногдох зардал /төгрөг/	1.0	0.96	0.83	0.13	86.5
10	Хөрөнгө оруулалт	117,195.7	1,852,170.0	11,247.5	1,840,922.5	0.6

### 3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 47.9 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 2 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залрууллаа.

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

Алдааны товч утга	Нийт алдаа		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
					Тоо	Дүн	Тоо	Дүн
Өмнөх оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт ашиг болон татвар төлөхийн өмнөх ашгийг 43.2 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн.	1	43,161.8	1	43,161.8	1	43,161.8		
Хойшлогдсон татварын хөрөнгө дансны 2020 онд үүссэн 4.7 сая төгрөгийн үлдэгдлийн алдагдлыг шилжүүлэн тооцох сүүлийн жил буюу 2024 онд бууруулж бичээгүй байна.	1	4,711.0	1	4,711.0	1	4,711.0		
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>47,872.8</b>	<b>2</b>	<b>47,872.8</b>	<b>2</b>	<b>47,872.8</b>		

3.2 Аудитаар нийт 6.3 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 6.3 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус компанийн 2024 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын илтгэх хуудсанд ашиглалтын бүртгэлийн картаар эзэмшиж буй бараа материалыг санхүүгийн тайлангийн үлдэгдлээс 0.6 сая төгрөгөөр дутуу, програм хангамжийг 1.0 сая төгрөгөөр илүү илэрхийлсэн байна.	1	1,672.9					1	1,672.9
Тайлант онд Тапатрип эжэнси ХХК-д шилжүүлсэн 4,581.0 сая төгрөгийг ибаримтгүйгээр гадаад томилолтын зардалд бүртгэж тайлагнасан байна.	1	4,581.0					1	4,581.0
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>6,253.9</b>					<b>2</b>	<b>6,253.9</b>